

Эсээ задлан шинэжлэх

Д. Урианхай “Гээгдсэн
гурван аугаа” эсээн
дээр

Монгол хэл 11-р анги
III улирлын 4-р хичээл

Д. Урианхай

Гээгдсэн гурван аугаа

Нялх хүүхдийг харсан хүн, хэрвээ нүдэн эс бүрхэг бөгөөс харсан даруйдаа л хайрлах сэтгэл алдуурч, хэрэвзээ хэл эс татмаг бөгөөс учирсан даруйдаа л өхөөрдөх үг унагана.

Хүүхдийн, харуут хайр булаам, үзүүт үгээ барам өхөөрдөм хөөрхөний “**учиг**” хүүхдийн “**хүүхэд чанар**” –ын гурван аугаад,

Үүнд: Гэнэний аугаад, Ариуны аугаад, Хоргүйн аугаад тус тус оршино.

Хүүхдийн Гэнэний аугаа нь, - ертөнцийн хатуугийн аугааг ажраана үгүй агаад, Ариуны аугаа нь: ертөнцийн нүглийн аугаад хүчирхэгдээнэ үгүй аугаад, Хоргүйн аугаа нь ертөнцийн атхагийн аугаад базагдаана үгүй аугаад тус тус хоргологдмуй.

Хурааваас, хүүхэд чанарын аугаа нь ертөнцийг хийгээд өөрийгөө ив ижил нэгэнд санадаг цагаан санааны хүчирхэгт оршмуй.

Ойрхи цагийн аюумшиг, гунигийн сурвалж нь өнөөгийн хүүхэд багачууд “ хүүхэд чанар” – аа гэесний харгай!

Эдүгээ ахуйн багачуудыг харахуйяа, хайрлахаасаа түрүүнд уурсах, өхөөрдөхөөсөө түрүүнд айх сэтгэл төрнөм. Яагаад ??

Учир ухаас, өнөө цагийн хүүхдүүд “ хүүхэд чанар” –ын гурван аугааг онхид гээжээ. Гурван аугаагийн гээгдэл, нэгд, ижийнхээ уураг сүүний нүнжгийг гэеснээс, хоёрт, эх нутгийнхаа эрчим, шимийн нүнжгийг гэеснээс, гуравт, элгэн төрөл ардынхаа эрдэм буяны нүнжгийг гэеснээс тус тус үүджээ.

1993.11.18- 1999.11.19

“ Нарлаг “ хороолол 33-а байр. 16-р өрөө

Эсээний сэдэв: Хүүхэд чанар !!!

Гол санаа: Хүүхэд чанарын аугаа нь ертөнцийг хийгээд өөрийгөө ив ижил нэгэнд санадаг цагаан санааны хүчирхэгт оршмуй.

Эсээний баримт: Нялх хүүхдийг харсан даруйдаа л хайрлах сэтгэл төрдөг, Учирсан даруйд өхөөрдөх үг унадаг. Хүүхдийн Гэнэн, Ариун, Хоргүй сэтгэл

Эсээний дүгнэлт: - Ижийнхээ уураг сүүний нүнжгийг гээснээс

- Эх нутгийнхаа эрчим шимийн нүнжгийг гээснээс

- Элгэн төрөл ардынхаа эрдэм буяны нүнжгийг гээснээс үүдсэн

Зохиолчийн үнэлэмж хандлага : Ойрх цагийн аюумшиг, гунигийн сурвалж нь өнөөгийн хүүхэд багачууд “ хүүхэд чанар” – аа гэсний харгай!

Эдүгээ ахуйн багачуудыг харахуйяа, хайрлахаасаа түрүүнд уурсах, өхөөрдөхөөсөө түрүүнд айх сэтгэл төрнөм. Яагаад ??

Нялх хүүхдийг харсан хүн, хэрвээ нүдэн эс бүрхэг бөгөөс харсан даруйдаа л хайрлах сэтгэл алдуурч, хэрэвзээ хэл эс татмаг бөгөөс учирсан даруйдаа л өхөөрдөх үг унагана.

Зохиолч ба бичвэр

- **Харуут – харангуут**
- **Үзүүт – үзэнгүүт**
- **Гэнэний аугаа, Ариуны аугаа, Хоргүйн аугаа**
- **Ажраана үгүй, хүчирхэгдээнэ үгүй, базагдаана үгүй**
- **Атхаг – атгаг**
- **Хоргологдмуй - оршмуй**
- **Ойрхи - эдүгээ**
- **Учир - ухваас**

Нэмэлт тэмдэглэгээ

Үүджээ...

Яагаад ??

Харгай !

“ хүүхэд чанар “

Нэгд, хоёрт, гуравт

Эсээний уран сайхан, хэл найруулга

- **нүдэн эс бүрхэг,
хэл эс татмаг бөгөөс**
- **сэтгэл алдуурах**
- **үг унагана.**
- **цагаан санаа**

Гээгдсэн гурван аугаа

Ерөнхий санаа:

Нялх хүүхдийг харсан хүн, хэрвээ нүдэн эс бүрхэг бөгөөс харсан даруйдаа л хайрлах сэтгэл алдуурч, хэрэвзээ хэл эс татмаг бөгөөс учирсан даруйдаа л өхөөрдөх үг унагана.

Түлхүүр өгүүлбэр:

Хүүхдийн, харуут хайр булаам, үзүүт үгээ барам өхөөрдөм хөөрхөний **“учиг”** хүүхдийн **“хүүхэд чанар”** –ын гурван аугаад

Баримт:

Үүнд: **Гэнэний** аугаад, **Ариуны** аугаад, **Хоргүйн** аугаад тус тус оршино.

Хүүхдийн Гэнэний аугаа нь, - ертөнцийн хатуугийн аугааг **ажраана үгүй** агаад, Ариуны аугаа нь: ертөнцийн нүглийн аугаад **хүчирхэгдээнэ үгүй** аугаад, Хоргүйн аугаа нь ертөнцийн атхагийн аугаад **базагдаана үгүй** аугаад тус тус хоргологдмуй.

Хурааваас, хүүхэд чанарын аугаа нь ертөнцийг хийгээд өөрийгөө ив ижил нэгэнд санадаг цагаан санааны хүчирхэгт оршмуй.

Үнэлэмж, хандлага:

Ойрхи цагийн аюумшиг, гунигийн **сурвалж** нь өнөөгийн хүүхэд багачууд “**хүүхэд чанар**” – аа гээсний **харгай!**

Эдүгээ ахуйн багачуудыг харахуйяа, хайрлахаасаа түрүүнд уурсах, өхөөрдөхөөсөө түрүүнд айх сэтгэл төрнөм. **Яагаад ??**

Дүгнэлт

Учир ухваас, өнөө цагийн хүүхдүүд “ **хүүхэд чанар**” –ын гурван аугааг онхид гээжээ. Гурван аугаагийн гээгдэл, **нэгд**, ижийнхээ уураг сүүний нүнжгийг гээснээс, **хоёрт**, эх нутгийнхаа эрчим, шимийн нүнжгийг гээснээс, **гуравт**, элгэн төрөл ардынхаа эрдэм буяны нүнжгийг гээснээс тус тус үүджээ.